





“ГОВИЙН ӨНДӨР” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар

Компанийн 2023 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөөг батлах тухай

“Говийн өндөр” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт №1-ээр баталсугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж санал хураасугай.
3. Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавиж ажиллахыг Гүйцэтгэх захирал П.Батбаяр-т үүрэг болгосугай

ХУРЛЫН ДАРГА



**“ГОВИЙН ӨНДӨР” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 29-ний өдөр

Дугаар 03


Улаанбаатар

Компанийн томоохон хувьцаа эзэмшигчид  
Өөрийн хөрөнгөөр компанийн байранд засвар үйлчилгээ  
хийхийг зөвшөөрөх тухай

“Говийн өндөр” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг  
үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Говийн Өндөр” ХК-ийн компанийн томоохон хувьцаа эзэмшигчид өөрийн хөрөнгөөр компанийн байранд засвар үйлчилгээ хийхийг зөвшөөрсүгэй.
2. Компанийн байранд засвар үйлчилгээ хийх явцын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал П.Батбаяр-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



*П. Батбаяр*



**“ГОВИЙН ӨНДӨР” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 29-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар

Их хэмжээний хэлцлийг батлах тухай

“Говийн өндөр” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Говийн Өндөр” ХК-ийн их хэмжээний хэлцлийг баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчдэд танилцуулахыг Гүйцэтгэх захирал П.Батбаяр-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА





**“ГОВИЙН ӨНДӨР” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 29-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон  
хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5.3 болон Тооллогын комиссын дүнг үндэслэн “Говийн Өндөр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Говийн Өндөр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:
  1. П.Эрдэнэцэцэг
  2. П.Батбаяр
  3. П.Эрдэнэчимэг
  4. П.Түмэнбаяр
  5. П.Ишдорж
  6. П.Рэнцэнхорол
  
2. “Говийн Өндөр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:
  1. С.Булган
  2. Д.Отгобаяр
  3. Э.Чойхүү нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

